

4.1 Хичээлийн жилийн хаалт, нээлтийн үйл ажиллагаа

Систем дээр “Хичээлийн жилийн хаалт” хийж дараагийн “Хичээлийн жилийн нээлт” хийх үйл ажиллагааг цэцэрлэгүүд өөрийн бүртгэлээр удирдана.



1. “Төгсөлт, дэвшилтийн бүртгэл”-ийг бүх бүлэг, суралцагчийн хувьд бүрэн баталгаажуулна.
2. “Төгсөлт, дэвшилтийн бүртгэл” -ээ бүх бүлэг, суралцагчийн хувьд бүрэн баталгаажуулж дуусгаад “Хичээлийн жилийн хаалт” үйлдэл хийнэ.
3. Цэцэрлэгүүд “ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ХААЛТ” үйлдлийг хийхэд дараагийн “ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН НЭЭЛТ” систем дээр хийгдэж дэвших суралцагч нь дараагийн анги бүлэгтээ дэвшин орж, төгсөх суралцагчид цэцэрлэгээс автоматаар хасагдана.

4.2 Хичээлийн жилийн хаалт хийх

Хичээлийн жилийн хаалтыг Боловсролын удирдлагын модулийн “Хичээлийн жилийн хаалт, нээлт” дэд модулийн тусламжтай удирдана.

№	Шалгуур	Үйлдэл	Огноо	Явц	Үр дүн	Алдаа
1	Суралцагчийн бүртгэл	Шалгах	2020-05-07		✓	Амжилттай ша...
2	Төгсөлт, дэвшилтийн бүртгэл	Шалгах	2020-05-07		⚠	8 алдаа
3	Шилжилт хөдөлгөөн	Шалгах	2020-05-07		⚠	3 алдаа

Хичээлийн жилийн хаалт хийхээс **өмнө дараах** гурван асуудлыг бүрэн шийдвэрлэсэн байх шаардлагатай.

1. Суралцагчийн бүртгэл
2. Шилжилт хөдөлгөөн
3. Төгсөлт, дэвшилтийн бүртгэл

Шалгуур тус бүрийн "**Шалгах**" товч дээр дарж алдаа байгаа эсэхийг шалгана.

Хэрэв шалгах явцад алдаа гарсан бол "Алдаа" баганы харгалзах мэдээлэл дээр дарж дэлгэрэнгүй мэдээллийг харна.

Алдааны жагсаалт: Шилжилт хөдөлгөөн						
№	Төрөл	Бүлэг	Суралцагч	Регистр	Алдааны тоо	Зөвлөмж
1	Хасуулах хүсэлт илгээсэн	18-бэлтгэл а (ө...	Т.Эрхэмбилэг			Баталгаажуулах хүсэлт модулийн...
2	Хасуулах хүсэлт илгээсэн	17-дунд-б (өмн...	С.Сангидорж			Баталгаажуулах хүсэлт модулийн...
3	Хасуулах хүсэлт ирсэн	18-бэлтгэл "б"	Ө.Мөнхцэцэг			"Баталгаажуулах хүсэлт" модулийн...

Алдаа тус бүрийг дараах байдлаар шийдвэрлэнэ.

1. Суралцагчийн бүртгэл

Хичээлийн жилийн хаалт хийхээс өмнө "Хянагдаж байгаа", "Цуцлагдсан", "Батлагдаагүй" суралцагчийн бүртгэлтэй холбоотой асуудлыг бүрэн шийдвэрлсэн байх шаардлагатай.

- **Хянагдаж байгаа** - төлөвтэй суралцагчийг Харьяалагдах аймаг, дүүргийн боловсролын газар, хэлтэстээ хандаж суралцагчийн бүртгэл баталгаажуулах хүсэлтийг шийдвэрлүүлнэ үү.
/Боловсролын удирдлага - Баталгаажуулах хүсэлт модульд/
- **Цуцлагдсан** - төлөвтэй суралцагчийн бүртгэлийг Боловсролын удирдлагын "Суралцагч" модулийн "Үйлдэл" цэсний "Үйлдэл буцаах" дээр дарж элсэлтийг цуцлана уу.
- **Батлагдаагүй** - төлөвтэй суралцагчийн бүртгэлийг "Суралцагч" модулийн "Үйлдэл" цэсний "Баталгаажуулах хүсэлт" дээр дарж баталгаажилт хийх эсвэл "Үйлдэл буцаах" товч дээр дарж элсэлтийг цуцлана уу.

4.3 Хичээлийн жилийн нээлтийн зөвлөмж

Бүлэгтэй холбоотой

- Бүлэг шинээр үүсгэх /Ж: Бага бүлэг болон бусад/
- Дараах тохиолдолд бүлгийн мэдээллийг шинэчлэх:
 - Анги удирдсан болон туслах багш өөрчлөгдсөн
 - Хичээллэх ээлж өөрчлөгдсөн
 - Хичээллэх танхим өөрчлөгдсөн
- "Бүлэг хоорондын шилжилт" хөдөлгөөн хийсний дараа ямар нэгэн суралцагчгүй бүлэг байвал бүртгэлийг устгах

Шилжилт хөдөлгөөнтэй холбоотой

- Шинээр элссэн болон шилжиж ирсэн суралцагчдыг бүртгэх
- Шаардлагатай бол суралцагчдын "Бүлэг хоорондын шилжилт" хөдөлгөөн хийх

Сургалтын орчин

- Тухайн цэцэрлэгт шинэ байр ашиглалтанд орсон бол шинээр бүртгэл хийх
- Цэцэрлэгийн байранд засвар үйлчилгээ, дэд бүтэцтэй холбоотой бүртгэл

Хүний нөөц

- Шаардлагатай бол шинэ ажлын байр үүсгэх
 - Хүний нөөцийн шилжилт хөдөлгөөн
 - Шинэ ажилтны бүртгэл
 - Ажлын харилцаа цуцлах
 - Албан тушаал өөрчлөх
 - Хэрэглэгчийн эрх
-